



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Засаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/188/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

дод 4.0д.дб № 17д
тантай _____-ны № _____-т

ЗАВХАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Г.МЯГМАРСҮРЭН-Д

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Биеийн тамир, спортын улсын хорооноос спортын арга хэмжээ зохион байгуулах зориулалтаар шилжиж ирсэн 70,000.0 мянган төгрөгийг аймгийн 100-н жилийн ойн хүлээн авалт болон морины бай шагналын зардалд, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас баяр наадмын үйл ажиллагаанд зориулан, нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн зардлаас "Завхан-100" хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох албан хаагчдын унааны зардалд 4,500.0 мянган төгрөг, "Steppe Arena" төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 6,512.0 мянган төгрөгийн албан томилолт олгосон, хүндэт зочдын буудлын төлбөрт 5,980.0 мянган төгрөг, хоолны зардалд 13,378.1 мянган төгрөг, гарын бэлэг худалдан авах зардалд 16,360.0 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан, үндсэн үйл ажиллагааны зардлаас байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардалд 8,400.0 мянган төгрөг зарцуулсан нь сургалт хийснийг нотлох тайлан, бусад холбогдох баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй ажлаар явсан, нутгийн зөвлөл, баяр наадмын комисс болон төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 19,199.0 мянган төгрөгийн, албан ёсны дуудсан бичиггүйгээр явсан ажилд 4,544.0 мянган төгрөгийн, дуудсан албан бичгээс 1-4 хоногээр илүү 4,218.0 мянган төгрөгийн томилолтыг тус тус тооцон олгож, албан томилолтын зардлыг үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3-д "Хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад",

15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 39,299.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 64,971.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 99,9811.8 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрээр акталж, 8,350.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсөвт байгууллагуудад шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 24 албан хаагчид 2,364.1 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдлийг илүү тооцож олгосон, аймгийн 100-н жилийн ойгоор идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан албан хаагчдад үнэ бүхий зүйл дурсгаж, гарын бэлэг худалдан авах зардалд 9,925.0 мянган төгрөг зарцуулсан, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон тэтгэвэрт гарсан албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд заасан гэх үндэслэлээр 1,400.0 мянган төгрөгийн тэтгэмж, Төрийн одон медалиар шагнуулсан 2 албан хаагчид 400.0 мянган төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгосон, ойн үйл ажиллагаанд 12,483.6 мянган төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулсан, аймгийн Засаг даргын зөвлөхийн орон тоонд 2 ажилтан ажиллуулж, 21,800.0 мянган төгрөгийн цалин олгосон зэрэг зөрчил байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн бүртгэлд үлдэх өртөггүй 278,784.7 мянган төгрөгийн 191 нэр төрлийн хөрөнгө байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	55,157,523.48	43,302,889.91
33	АВЛАГА	1,062,668.90	699,839.48
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	475,000.00	575,000.00
33500	Бусад авлага	587,668.90	124,839.48
33510	Байгууллагаас авах авлага	587,668.90	124,839.48
35	БАРАА МАТЕРИАЛ	54,094,854.58	42,603,050.43
35400	Хангамжийн материал	54,094,854.58	42,603,050.43
35410	Бичиг хэргийн материал	438,000.00	1,407,500.00
35420	Аж ахуйн материал	6,803,990.00	4,537,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,901,000.00	0
35440	Түлш, шатах тослох материал	6,018,213.97	36,324,549.82
35460	Хүнсний материал	0.04	0.04
35470	Бусад хангамжийн материал	38,933,650.57	334,000.57
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,025,259,561.09	2,927,004,115.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,025,259,561.09	2,927,004,115.20
39200	Биет хөрөнгө	2,887,008,961.09	2,788,841,515.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,745,580,358.52	2,745,580,358.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	-176,381,677.14	-223,410,393.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	581,703,000.00	543,675,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-531,583,555.60	-522,174,999.84
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	278,031,181.79	300,116,820.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	-139,389,073.06	-134,603,815.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	313,053,647.19	288,934,918.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-184,096,121.20	-209,357,441.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	608,000.00	608,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-516,799.41	-526,932.69
39300	Биет бус хөрөнгө	138,250,600.00	138,162,600.04
39301	Программ хангамж	890,000.00	890,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-537,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	137,810,600.00	137,810,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,080,417,084.57	2,970,307,005.11
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,080,417,084.57	2,970,307,005.11
51	Засгийн газрын хувь оролцоо	3,080,417,084.57	2,970,307,005.11
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,817,285,112.85	2,817,285,112.85
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,817,285,112.85	2,817,285,112.85
51200	Хуримтлагдсан үр дүн	-16,498,145.52	-126,608,224.98
51210	Өмнөх үеийн үр дүн	-538,990,209.40	-16,498,145.52
51220	Тайлант үеийн үр дүн	522,492,063.88	-110,110,079.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	279,630,117.24	279,630,117.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,080,417,084.57	2,970,307,005.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгсгөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,448,329,032.7	5,022,401,204.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	625,534,786.0	106,947,720.4
120	Нийтлэг татварын бус орлого	625,534,786.0	106,947,720.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	625,534,786.0	36,619,920.4
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,375,977.0	7,648,445.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	608,158,809.0	28,971,475.4
120009	Бусад орлого	0.0	70,327,800.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,822,794,246.7	4,915,453,484.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,334,072,446.7	711,857,084.1
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,334,072,446.7	711,857,084.1
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,488,721,800.0	4,203,596,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,488,721,800.0	4,203,596,400.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,925,836,968.8	5,129,551,338.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,925,836,968.8	5,129,551,338.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,523,847,903.5	4,629,296,859.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,079,954,358.0	1,778,470,746.5
210101	Үндсэн цалин	627,698,505.0	1,007,645,409.6
210102	Нэмэгдэл	199,085,764.2	535,106,396.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,200,000.0	96,929,125.9
210104	Урамшуулал	40,547,335.0	136,746,811.6
210105	Гэрээт ажлын хөлс	141,422,753.9	2,043,002.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,311,689.3	222,164,762.0
210201	Тэтгэврийн даатгал	96,627,106.7	152,104,647.1
210202	Тэтгэмжийн даатгал	9,557,727.5	17,255,589.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,595,842.1	13,602,071.1
210204	Ажилгүйдлийн даатгал	1,858,488.1	3,382,678.4
210205	Эрүүл мэндийн даатгал	19,672,525.0	35,819,776.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,417,944.6	242,004,741.8
210301	Гэрэл, цахилгаан	12,131,804.6	15,546,693.0
210302	Түлш, халаалт	208,331,200.0	198,575,308.8
210303	Цэвэр, бохир ус	14,954,940.0	21,882,740.0
210304	Байрны түрээс	0.0	6,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	165,199,003.1	228,496,795.4
210401	Бичиг хэрэг	17,410,600.0	22,359,240.0
210402	Тээвэр, шатахуун	102,440,704.0	116,691,564.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,539,499.1	16,086,774.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,808,200.0	69,134,227.0
210408	Бараа материал акталсны зардал	0.0	4,224,990.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,098,350.0	110,631,100.0
210604	Урсгал засвар	80,098,350.0	110,631,100.0
2107	Томилолт, зочны зардал	51,658,340.0	126,362,450.0
210702	Дотоод албан томилолт	51,658,340.0	126,362,450.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,442,883.0	20,760,877.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,391,400.0	8,519,613.0
210803	Даатгалын үйлчилгээ	6,836,000.0	6,835,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	526,830.0	545,564.0

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	187,000.0	187,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,522,000.0	3,606,000.0
210807	Газрын төлбөр	979,653.0	1,066,800.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,764,765,335.4	1,900,405,386.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,632,841,960.4	1,736,839,112.9
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	131,923,375.0	163,566,273.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	401,989,065.4	500,254,479.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	189,170,290.0	124,405,876.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.0	4,500,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	84,517,827.0	17,795,800.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	104,652,463.0	102,110,076.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	212,818,775.4	375,848,603.2
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,972,375.3	9,941,668.5
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	117,846,400.1	365,906,934.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	522,492,063.9	-107,150,133.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	2,959,945.7
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.0	2,959,945.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-	522,492,063.9	-110,110,079.5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,840,170,223.7	4,993,429,729.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,375,977.0	7,976,245.0
120	Нийтлэг татварын бус орлого	17,375,977.0	7,976,245.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,375,977.0	7,648,445.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,375,977.0	7,648,445.0
120009	Бусад орлого	0.0	327,800.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,822,794,246.7	4,985,453,484.1
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,334,072,446.7	781,857,084.1
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	70,000,000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,334,072,446.7	711,857,084.1
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,488,721,800.0	4,203,596,400.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,488,721,800.0	4,203,596,400.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,779,541,873.7	4,954,130,431.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,779,541,873.7	4,954,130,431.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,377,562,808.3	4,453,875,952.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,080,429,358.0	1,778,164,517.1
210101	Үндсэн цалин	593,909,254.0	1,007,656,858.1
210102	Нэмэгдэл	193,801,611.3	537,014,541.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,944,998.2	100,098,031.7
210104	Урамшуулал	40,547,335.0	127,746,459.4
210105	Гэрээт ажлын хөлс	185,226,159.6	5,648,626.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,797,668.8	222,164,762.0

210201	Тэтгэврийн даатгал	97,113,086.1	151,976,963.8
210202	Тэтгэмжийн даатгал	9,557,727.5	17,546,924.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,595,842.1	14,037,479.6
210204	Ажилгүйдлийн даатгал	1,858,488.1	3,509,444.5
210205	Эрүүл мэндийн даатгал	19,672,525.0	35,093,949.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,417,944.6	242,004,741.8
210301	Гэрэл, цахилгаан	12,131,804.6	15,546,693.0
210302	Түлш, халаалт	208,331,200.0	198,575,308.8
210303	Цэвэр, бохир ус	14,954,940.0	21,882,740.0
210304	Байрны түрээс	0.0	6,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	151,379,553.6	211,305,774.2
210401	Бичиг хэрэг	16,007,850.0	22,869,440.0
210402	Тээвэр, шатахуун	106,997,900.0	146,997,900.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,504,103.6	16,030,174.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,869,700.0	25,408,260.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,298,350.0	107,250,100.0
210604	Урсгал засвар	78,298,350.0	107,250,100.0
2107	Томилолт, зочны зардал	50,979,090.0	126,362,450.0
210702	Дотоод албан томилолт	50,979,090.0	126,362,450.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,442,883.0	20,760,877.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,391,400.0	8,519,613.0
210803	Даатгалын үйлчилгээ	6,836,000.0	6,835,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	526,830.0	545,564.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	187,000.0	187,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,522,000.0	3,606,000.0
210807	Газрын төлбөр	979,653.0	1,066,800.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,633,817,960.4	1,745,862,729.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,633,817,960.4	1,745,862,729.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	401,979,065.4	500,254,479.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	189,160,290.0	124,405,876.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.0	4,500,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	84,517,800.0	17,795,800.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	104,642,490.0	102,110,076.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	212,818,775.4	375,848,603.2
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,972,375.3	9,941,668.5
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	117,846,400.1	365,906,934.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	60,628,350.0	39,299,298.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	60,628,350.0	39,299,298.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,628,350.0	39,299,298.0
2200	Дотоод эх үүсвэрээр	60,628,350.0	39,299,298.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	60,628,350.0	39,299,298.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-60,628,350.0	-39,299,298.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,817,285,112.9	279,630,117.2	-595,263,359.4	2,501,651,870.7
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,817,285,112.9	279,630,117.2	-16,498,145.5	3,080,417,084.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,817,285,112.9	279,630,117.2	-538,990,209.4	2,557,925,020.7
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	522,492,063.9	522,492,063.9
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,817,285,112.9	279,630,117.2	-16,498,145.5	3,080,417,084.6
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,817,285,112.9	279,630,117.2	-126,608,225.0	2,970,307,005.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,817,285,112.9	279,630,117.2	-16,498,145.5	3,080,417,084.6
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-110,110,079.5	-110,110,079.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,218,683,600.0	4,201,630,976.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,218,683,600.0	4,201,630,976.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,093,913,300.0	4,077,225,100.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,752,672,400.0	1,752,672,400.0
210101	Үндсэн цалин	982,099,900.0	994,849,880.7
210102	Нэмэгдэл	643,588,500.0	533,747,514.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	126,984,000.0	96,739,032.6
210104	Урамшуулал	0.0	127,335,972.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	219,084,000.0	219,083,944.6
210201	Тэтгэврийн даатгал	148,977,100.0	148,977,044.6
210202	Тэтгэмжийн даатгал	17,526,700.0	17,526,700.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,021,300.0	14,021,300.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,505,400.0	3,505,399.6
210205	Эрүүл мэндийн даатгал	35,053,500.0	35,053,500.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,802,400.0	242,004,741.8
210301	Гэрэл, цахилгаан	19,225,800.0	15,546,693.0
210302	Түлш, халаалт	198,576,600.0	198,575,308.8
210303	Цэвэр, бохир ус	24,000,000.0	21,882,740.0
210304	Байрны түрээс	6,000,000.0	6,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	204,500,300.0	204,500,024.2
210401	Бичиг хэрэг	18,902,400.0	18,603,690.0
210402	Тээвэр, шатахуун	146,997,900.0	146,997,900.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,600,000.0	16,030,174.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,000,000.0	22,868,260.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	110,857,500.0	107,250,100.0

210604	Урсгал засвар	110,857,500.0	107,250,100.0
2107	Томилолт, зочны зардал	133,910,100.0	128,922,450.0
210702	Дотоод албан томилолт	133,910,100.0	128,922,450.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,020,200.0	49,728,675.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,500,000.0	37,487,411.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	6,836,000.0	6,835,900.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	550,000.0	545,564.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	700,000.0	187,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,606,000.0	3,606,000.0
210807	Газрын төлбөр	1,820,200.0	1,066,800.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,373,066,400.0	1,373,062,764.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,373,066,400.0	1,373,062,764.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,770,300.0	124,405,876.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,770,300.0	124,405,876.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,500,000.0	4,500,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,795,800.0	17,795,800.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	102,474,500.0	102,110,076.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,218,683,600.0	4,201,630,976.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,203,596,400.0	4,193,982,531.5
320001	Орон нутгийн төсвөөс	4,203,596,400.0	4,193,982,531.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,087,200.0	7,648,445.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,087,200.0	7,648,445.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		781,857,084.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ		781,857,084.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		415,950,149.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		12,806,977.36
210101	Үндсэн цалин		3,267,026.83
210102	Нэмэгдэл		3,358,999.05
210104	Урамшуулал		410,487.28
210105	Гэрээт ажлын хөлс		5,648,626.53
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл		3,080,817.39
210201	Тэтгэврийн даатгал		2,999,919.15
210202	Тэтгэмжийн даатгал		20,224.56
210203	ҮОМШӨ-ний даатгал		16,179.64
210204	Ажилгүйдлийн даатгал		4,044.92
210205	Эрүүл мэндийн даатгал		40,449.12
2104	Хангамж, бараа материалын зардал		6,805,750
210401	Бичиг хэрэг		4,265.750
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,504,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		380,571,465
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		380,571,465
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		365,906,934.68
2134	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		365,906,934.68
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		365,906,934.68

13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	781,857,084.12
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	781,857,084.12
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	70,000,000
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	711,857,084.12

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиг үүрэг: Төрийн бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх

Аймгийн Засаг даргын Тамгын газрын зорилго: Иргэдийн оролцоонд тулгуурласан ил тод, хариуцлагатай, чадварлаг, үр дүнг эрхэмлэсэн төрийн албыг төлөвшүүлж, аймгийнхаа хөгжил, дэвшлийг оновчтой бодлого, зохицуулалтаар хангахад оршино.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.4 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэд дотоод аудитын чиг үүрэг бүхий аудитор байхгүй байна. Тус байгууллагын санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд Тамгын газрын дарга болон Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, төлбөр тооцооны мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 74,110.1 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,062.7	699.8	(362.9)
Бараа материал	54,094.8	42,603.0	(11,491.8)
Үндсэн хөрөнгө	3,025,259.6	2,963,004.1	(62,255.5)
Нийт хөрөнгө	3,080,417.1	3,006,307.0	(74,110.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,080,417.1	3,006,307.0	(74,110.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,080,417.1	3,006,307.0	(74,110.1)

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Авлагын эхний үлдэгдэл 1,062.7 мянган төгрөг, тайлант онд 362.9 мянган төгрөгөөр барагдаж, эцсийн үлдэгдэл 699.8 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 54,094.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 333,383.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 340,650.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 42,603.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,491.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 39,299.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 45,099.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 38,028.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар борлуулж, 61,953.8 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, 8,350.1 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг төсөвт байгууллагад шилжүүлж, жилийн эцэст 2,963,004.1 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 163,566.3 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 74,110.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,661,602.1 мянган төгрөг, нийт зарлагыг 5,661,602.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас шатахуун, дотоод албан томилолт, Засаг даргын нөөц хөрөнгийг бууруулж баталсан байна. Тайлант онд цалин нэмэгдсэнтэй холбогдуулан тодотголоор цалин, ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийг нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,218,683.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,201,631.0 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна. Энэ нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5,797.6 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 3,607.4 мянган төгрөгөөр, дотоод албан томилолтыг 4,987.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,291.5 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмжийг 364.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Орон нутгийн төсвөөс санхүүжих					
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,487,679.2	2,471,007.1	16,672.1	99.3%
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	284,167.4	284,167.4	-	100%
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	37,500.0	37,487.4	12.6	99.9%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	120,270.3	119,905.9	364.4	99.7%
80813	Хуульд заасан үндэслэлээр олгох	4,500.0	4,500.0	-	100%
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	1,284,566.4	1,284,562.9	3.5	99.99%
НИЙТ		4,218,683.6	4,201,631.0	17,052.6	99.6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 781,857.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 415,950.2 мянган төгрөгийг төрийн архивын тасгийн гэрээт ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хангамж, бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, Сангийн сайдын багцаас аймгийн Төрөх эмнэлэг, Дөрвөлжин сумын Засаг даргын Тамгын газар, Отгон сумын Эрүүл мэндийн төвийн засварын зардалд олгосон 303,286.0 мянган төгрөгийн санхүүжилт болон зарцуулаагүй үлдэгдэл 62,620.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Нээлттэй тендер шалгаруулалт	Шатах тослох материал	122,780,300	122,780,300
2	Шууд гэрээ байгуулах	Архивын тоног төхөөрөмж худалдаж авах	8,561,900	8,561,900
3	Шууд гэрээ байгуулах	Тоног төхөөрөмж худалдаж авах	17,817,800	17,817,800
4	Шууд гэрээ байгуулах	Тоног төхөөрөмж худалдаж авах	11,150,000	11,150,000
ДҮН			160,310,000	160,310,000

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03/60 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,908,413.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 73,626.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 55,219.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,129,551.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 76,943.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 57.707.5 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 38 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд аймгийн 100 жилийн ойгоор идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан гэх үндэслэлээр байгууллагын албан хаагчдад 9,925,000 төгрөгийн үнэ бүхий зүйл дурсгаж, гарын бэлэг өгсөн, Орон нутгийн хөгжлийн сангаас баяр наадмын үйл ажиллагаанд зориулан, нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн зардлаас гарын бэлэг худалдан авах зардалд 16,360.0 мянган төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны зардлаас байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардалд 8,400.0 мянган төгрөг зарцуулсан нь сургалт хийснийг нотлох тайлан, бусад холбогдох баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон тэтгэвэрт гарсан албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд заасан гэх үндэслэлээр 1,400.0 мянган төгрөгийн тэтгэмж, Төрийн одон медалиар шагнуулсан 2 албан хаагчид 400.0 мянган төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгож, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн зөрчилд албан шаардлага өгсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж, аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 795,299.9 мянган төгрөгийн, нярвын хувийн дансаар 9,950.0 мянган төгрөгийн шагналын мөнгө дамжуулан зарцуулж, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй зөрчилд зөвлөмж өгч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 32,362.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 23,662.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 8,700.0 мянган төгрөгийн

төлбөрийн акт төлөгдөөгүй байна. 275,819.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдөж, 264,459.6 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	32,362.5	1	23,662.5	73.1%
Албан шаардлага	1	275,819.6	1	264,459.6	97.7%
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	2	308,182.1	3	288,122.1	93.5%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Засаг даргын нөөц хөрөнгө, дотоод албан томилолт, шатахууны зарцуулалт болон жолоочийн тооцооны хуудас, бараа материалын тайланг анхаарч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,453.8 мянган төгрөгийн алдаа илэрч, аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 36,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, бараа материалын тодруулга тайлан, ерөнхий журналыг тулган шалгахад 453.8 мянган төгрөгийн бараа материалыг тодруулга тайлангаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасан, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 201,463.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 12,289.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 189,174.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн 201,463.7 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 124,520.4 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аймгийн 100 жилийн ойгоор идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан гэх үндэслэлээр байгууллагын албан хаагчдад 9,925,000 төгрөгийн үнэ бүхий зүйл дурсгаж, гарын бэлэг өгсөн болон албан хаагчдад 2,364,068 төгрөгийн илүү цагийн нэмэгдлийг илүү тооцож, олгосон зөрчилд 2 төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Биеийн тамир, спортын улсын хорооноос спортын арга хэмжээ зохион байгуулах зориулалтаар шилжиж ирсэн 70,000.0 мянган төгрөгийг аймгийн 100 жилийн ойн хүлээн авалт болон морины бай шагналын зардалд, аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас баяр наадмын үйл ажиллагаанд зориулан, нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн зардлаас "Завхан-100" хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох алба хаагчдын унааны зардалд 4,500.0 мянган төгрөг, "Steppe Arena" төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 6,512.0 мянган төгрөгийн албан томилолт олгож, хүндэт зочдын

буудлын төлбөрт 5,980.0 мянган төгрөг, хоолны зардалд 13,378.1 мянган төгрөг, гарын бэлэг худалдан авах зардалд 16,360.0 мянган төгрөгийг тус тус зориулалт бусаар зарцуулсан, үндсэн үйл ажиллагааны зардлаас байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардалд 8,400.0 мянган төгрөг зарцуулсан нь сургалт хийснийг нотлох тайлан, бусад холбогдох баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй ажлаар явсан, нутгийн зөвлөл, баяр наадмын комисс болон төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 19,199.0 мянган төгрөгийн, албан ёсны дуудсан бичиггүйгээр явсан ажилд 4,544.0 мянган төгрөгийн, дуудсан албан бичгээс 1-4 хоногоор илүү 4,218.0 мянган төгрөгийн томилолтыг тус тус тооцон олгож, албан томилолтын зардлыг үрэлгэн зарцуулсан, Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон тэтгэвэрт гарсан албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд заасан гэх үндэслэлээр 1,400.0 мянган төгрөгийн тэтгэмж, Төрийн одон медалиар шагнуулсан 2 албан хаагчид 400.0 мянган төгрөгийн дагалдах мөнгөн шагнал олгож, аймгийн 100-н жилийн ойн үйл ажиллагаанд 12,483.6 мянган төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулсан, аймгийн Засаг даргын зөвлөхийн орон тоонд 2 хүнийг томилон ажиллуулж, төсвөөс 21,800.0 мянган төгрөгийн цалин олгосон зөрчилд 3 албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруу-лаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.	1	36,000.0	1	36,000.0			1	36,000.0				
Бараа материалын тодруулга тайлан, ерөнхий журналыг тулган шалгахад 453.8 мянган төгрөгийн бараа материалыг тодруулга тайлангаар дамжуулаагүй шууд зардлаар бүртгэсэн	1	453.8			1	453.8	1	453.8				
Дүн	2	36,453.8	1	36,000.0	1	453.8	2	36,453.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
24 албан хаагчид илүү цагийн нэмэгдлийг Засгийн газрын тогтоол зөрчиж, илүү тооцож олгосон.	1	2,364.1	1	2,364.1								
Аймгийн 100 жилийн ойгоор идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан гэх үндэслэлээр байгууллагын албан хаагчдад 9,925,000 төгрөгийн үнэ бүхий зүйл дурсгаж, гарын бэлэг өгсөн	1	9,925.0	1	9,925.0								
Аймгийн 100 жилийн ойн үйл ажиллагаанд 12,483.6 мянган төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулсан байна.	1	12,483.5			1	12,483.5						

Биеийн тамир, спортын улсын хорооноос аймгийн Биеийн тамир спортын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар шилжиж ирсэн 70,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 40,000.0 мянган төгрөгийг хүлээн авалтын зардалд, 30,000.0 мянган төгрөгийг морины бай шалгалд зориулалт бусаар зарцуулсан. Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.	1	70,000.0	1	70,000.0																
Аймгийн ОНХС-аас нэмэлт санхүүжилтийн дансаар дамжсан баяр наадмын зардлаас "Завхан-100" хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох автобусны зардал 4,500.0 мянган төгрөг гаргаж, "Sterre Arena" төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 6,512.0 мянган төгрөгийн албан томилолт олгосон, хүндэт зочдын буудлын төлбөрт 5,980.0 мянган төгрөг, хоолны үнэ, ус ундаанд 13,378.1 мянган төгрөг, гарын бэлэгний үнэ 16,360.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан.	1	46,730.1	1	46,730.1																46,730.1
Албан томилолтыг түүвэрлэн шалгахад төрийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй ажлаар явсан, нутгийн зөвлөл, баяр наадмын комисс болон төрийн бус байгууллагын тамга, тэмдгээр баталгаажуулсан томилолтын хуудсаар 19,199.0 мянган төгрөгийн, албан ёсны дуудсан бичиггүйгээр явсан ажилд 4,544.0 мянган төгрөгийн, дуудсан албан бичгээс 1-4 хоногоор илүү 4,218.0 мянган төгрөгийн томилолтыг тус тус тооцон олгож, албан томилолтын зардлыг үрэлгэн зарцуулсан	1	27,961.0	1	27,961.0																27,961.0
Байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын зардалд 8,400.0 мянган төгрөг зарцуулсан нь сургалт хийснийг нотлох тайлан, бусад холбогдох баримтгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.	1	8,400.0	1	8,400.0																8,400.0
Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн болон тэтгэвэрт гарсан албан хаагчдад Хөдөлмөрийн дотоод журамд заасан гэх үндэслэлээр 1,400.0	1	1,800.0	1	1,800.0																1,800.0

